



"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН

2020 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

04 КОМПАНИЙН ТУХАЙ

- Компанийн ерөнхий танилцуулга, бүтэц
- 06 Компанийн онцлох үйл явдлууд

07 УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

- Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
- Гүйцэтгэх удирдлага
- 08 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл

09 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр
- Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт

09 НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

10 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

12 КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Буцаахгүй нөхцөлтэй хэлцэл
- 12 Үнэт цаасжуулалт - Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)
- 16 Буцаах нөхцөлтэй хэлцэл

ЭРХЭМ ЗОРИЛГО

Компанийн эрхэм зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаадын хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэхэд оршино.



КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн ерөнхий танилцуулга, бүтэц


“МИК Холдинг” ХК нь Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй компани бөгөөд МИК Групп компанийн толгой компани юм.

МИК Групп компани нь “МИК Холдинг” ХК болон түүний охин компаниуд болох “Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК (“МИК ОССК” ХХК), “МИК Рийл Эстэйт” ХХК, “Протегио Ферст” ХХК болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор үүсгэн байгуулсан 25 тусгай зориулалтын компаниудаас бүрдэн үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар “Протегио Ферст” ХХК үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байна.


Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



“МИК Холдинг” ХК-ийн бүтэц



"МИК Холдинг" ХК нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар дараах бүтэц бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Эдгээр удирдлага, албан тушаалтнууд "МИК Холдинг" ХК, "МИК ОССК" ХХК болон түүний охин компани болох 25 тусгай зориулалтын компаниуд, "МИК Рийл Эстэйт" ХХК, "Протего Ферст" ХХК-ийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор хамтран ажиллаж байна.

Компанийн зээлжих зэрэглэл

2018 оноос "МИК Холдинг" ХК болон түүний охин компани "МИК ОССК" ХХК нь зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэж байна. Тайлант хугацаанд компанийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг "Мүүдис" агентлаг "B3", сөрөг хэмээн бууруулсан бол "Стандарт энд Пүүрс" агентлаг "B", тогтвортой хэмээн баталгаажууллаа.

MOODY'S

B3

Negative

S&P Global
Ratings

B

Stable

Онцлох үйл явдалууд



"МИК Актив Хорин Хоёр ТЗК" ХХК 95.3 тэрбум, "МИК Актив Хорин Гурав ТЗК" ХХК 87.5 тэрбум төгрөгийн ИЗББ тус тус гаргав.



"МИК Холдинг" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулав.

Монголбанк, Сангийн яам, "МИК ОССК" ХХК болон арилжааны банкууд ипотекийн зээлийн эргэн төлөлтийг 6 сараар хойшлуулж анхүүжгийн хүндрэлийг бууруулахаар шийдвэрлэв.



1-р сар

2-р сар

3-р сар

4-р сар

5-р сар

6-р сар



"МИК Холдинг" ХК-ийн ээлжит бус Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулав.



Зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацаагаар өөрчлөлт оруулав.



Монголбанк, арилжааны банкууд болон МИК "Орон сууны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ"-г шинэчлэн байгуулав.

Moody's
B3
Negative

Компанийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг "Мүүдис" агентлаг "B3" сөрөг болгон бууруулав.

S&P Global
Ratings

B

Stable

Компанийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг "Стандарт энд Пүүрс" агентлаг "B" тогтвортой хэмээн дахин баталгаажуулав.

УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн тухай хуульд Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна гэж заасны дагуу “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь “МИК ОССК” ХХК, “Протега Ферст” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрх болон ТУЗ-ийн хурлын бүрэн эрх, “МИК Рийл Эстэйт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд, “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ 2 удаа, “МИК ОССК” ХХК-ийн ТУЗ 12 удаа, ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо 11 удаа, Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо 2 удаа, Эрсдэлийн удирдлагын хороо 2 удаа тус тус хуралдан холбогдох чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргаж, үйл ажиллагааг чиглүүлэн хяналт тавьж ажилласан.

ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүн

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг, Компанийн дүрэмд заасны дагуу 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатайгаар сонгосон бөгөөд ТУЗ нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

М.Мөнхбаатар нь Улаанбаатар хотын банкны зөвлөх, 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн даргаар улиран сонгогдсон бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны даргаар мөн ажилладаг.

Д.Аюуш нь Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хорооны дарга болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Б.Чойжилжалбуу нь Монгол Улсын Хөгжлийн банкны Актив, пассив, хөрөнгийн удирдлагын газрын захирал. ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хорооны гишүүнээр ажилладаг.

Т.Даваажав нь Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал. ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн болон Санхүү, аудитын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

С.Батчимэг нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал. ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Б.Гантулга нь “МИК Холдинг” ХК болон түүний охин компани “МИК ОССК” ХХК, “Протега Ферст” ХХК-ийн Гүйцэтгэх захирал. ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Үйл ажиллагаа, эрх зүйн хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Ч.Хашчулуун нь Монгол Улсын Их Сургуулийн Дэд профессор. ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо, Үйл ажиллагаа эрх зүйн хороо болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Э.Шижир нь Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийн удирдагч. ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хорооны дарга болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Ч.Отгочулуу нь “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-ийн зөвлөх, ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Санхүү, аудитын хорооны гишүүн болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Гүйцэтгэх удирдлага

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус хурлын шийдвэрээр Бадамхатангийн Гантулгыг Гүйцэтгэх захирлаар томилсон.

Гүйцэтгэх захирлын талаарх мэдээлэл

Б.Гантулга нь 1997-2001 онд Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургуулийг Санхүүч, эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, 2007-2008 онд Австрали улсын Австралийн үндэсний их сургуульд санхүүгийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалсан. Төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагад ажиллаж байсан туршлагатай.

Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах эрхийн хүрээнд дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн гүйцэтгэх захирлын хувиар компанийн болон бизнес хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар ТУЗ-д саналаа танилцуулж, чиглэл авч компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, хууль тогтоомжид заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд тухай бүрд нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний дагуу оролцох;
- Компанийн хөрөнгийн удирдлага, өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанаас бусад компанийн хөрөнгө оруулалт, бусад эд хөрөнгө худалдах, худалдан авах зэрэг хэлцлийг ТУЗ-өөс олгосон

Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1.	Б.Гантулга	Гүйцэтгэх захирал	Монгол
2.	Г.Саруул	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Монгол
3.	Ц.Алтантуяа	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Монгол

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 20/05 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 85.93 хувийн ирцтэйгээр хуралдаж, 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн зардлын төсвийг хэлэлцэж баталсан.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

“МИК Холдинг” ХК нь 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 213 хувьцаа эзэмшигчтэй байна.

“МИК Холдинг” ХК-ийн 5 хувиас дээш хувьцаа эзэмшигчид:

Монгол Улсын хөгжлийн банк	14.88%
“Азиа дайверсифайд рийл эстэйт фонд нэг хувийн ХОС” ХХК	11.17%
Улаанбаатар хотын банк	10.00%
Худалдаа хөгжлийн банк	9.99%
“Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК	9.22%

Эх сурвалж: “ҮЦТХТ” ХХК

НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлын 20/02 дугаар тогтоолоор компанийн 2019 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2020 оны хагас жилийн байдлаар "МИК Актив ТЗК 1-23" ХХК-ийн давуу эрхтэй бонд эзэмшигчдийн үндсэн төлбөрт 132.2 тэрбум төгрөг, давуу болон энгийн эрхтэй бондын купоны төлбөрт 77.1 тэрбум төгрөгийг тус тус төлөөд байна.

МИК Групп компанийн 2020 оны 6 дугаар сарын 30-ны байдлаарх санхүүгийн байдлын тайлан

	сая.төг
ХӨРӨНГӨ	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	214,697.07
Дансны авлага	9,011.57
Хөрөнгө оруулалт	207,433.56
Бусад санхүүгийн хөрөнгө	3,694,704.06
Бусад санхүүгийн бус хөрөнгө	66,617.11
Үндсэн хөрөнгө	31,870.15
Биет бус хөрөнгө	152.88
Нийт хөрөнгийн дүн	4,224,486.40
ӨР ТӨЛБӨР	
Дансны өглөг	-
Татварын өр	6,663.24
Хүүний өглөг	65,879.32
Урьдчилж орсон орлого	-
Бусад богино хугацаат өр төлбөр	7,087.65
Богино хугацаат зээл	-
Урт хугацаат зээл	69,249.32
Бусад урт хугацаат өр төлбөр	3,818,850.41
Нийт өр төлбөр	3,967,729.94
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	
Хувьцаат өмч	20,709.32
Халаасны хувьцаа	(62,143.13)
Нэмж төлөгдсөн капитал	52,225.11
Нөөц хөрөнгө	251,852.53
Тайлант оны ашиг	(5,887.36)
Нийт өөрийн хөрөнгө	256,756.47
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	4,224,486.40

Нийт активын хэмжээ 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 4,224.5 тэрбум төгрөг хүрч, тайлант хугацаанд 24.4 тэрбум төгрөгийн цэвэр хүүний орлого, 30.3 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар татварын дараах цэвэр алдагдал 5.9 тэрбум төгрөг гарсан байна.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

АШИГТ АЖИЛЛАГАА

Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	-0.28%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	-4.53%

ӨӨРЧЛӨЛТИЙН ХУВЬ (ОНЫ ЭХНЭЭС)

Нийт активын өөрчлөлт	1.0%
Зээлийн багцын өөрчлөлт	0.7%

ХӨРӨНГӨНД ЭЗЛЭХ ХУВЬ

Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	6.08%
Зээлийн багц/Нийт хөрөнгө	85.80%
Өэлүн бонд/Нийт хөрөнгө	19.24%

Эх сурвалж: "МИК ОССК" ХХК

Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт хөрөнгийн өгөөжийн хувь -0.3%, өөрийн хөрөнгийн өгөөж -4.5% тус тус үзүүлэлттэй байна.

Оны эхэн үетэй харьцуулахад нийт активын хэмжээ 1.0%-аар, нийт багцын хэмжээ 0.7%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь 2020 оны эхний хагас жилд "МИК Актив Хорин Хоёр ТЗК" ХХК болон "МИК Актив Хорин Гурав ТЗК" ХХК-ийг шинээр үүсгэн байгуулан 182.94 тэрбум төгрөгийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд нэмж гаргасантай холбоотой юм.

Тайлант хугацааны эцэст нийт өөрийн хөрөнгийн хэмжээ нийт хөрөнгийн 6.1%, нийт зээлийн хөрөнгийн багцын хэмжээ 85.8% болон шинээр гаргасан "Өэлүн" бондын хэмжээ нийт хөрөнгийн 19.2%-ийг тус тус бүрдүүлж байна.

КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“МИК ОССК” ХХК нь ипотекийн анхдагч зах зээл дээр эрх бүхий байгууллагуудаас олгогдсон ипотекийн зээлийн хөрөнгийг **Буцаах** болон **Буцаахгүй** нөхцөлтэй хэлцэл хийх замаар багцлан худалдан авах үндсэн үйл ажиллагаа явуулдаг.

Буцаахгүй нөхцөлтэй хэлцэл

“МИК ОССК” ХХК нь Монгол Улсын Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгогдсон орон сууцны ипотекийн зээлийг багцлан, буцаахгүй нөхцөлтэй хэлцлээр банкуудаас худалдан авч, ИЗББ-оор солих үйл ажиллагаа явуулж байна.

Уг хэлцлийн хүрээнд МИК аливаа зээлийн хөрөнгийн багцыг худалдан авахдаа тухайн зээлийн хөрөнгийн бүхий л эрх, үр өгөөж болон учирч болох эрсдэлийг бүхэлд нь өөртөө шилжүүлж авдаг буюу уг хэлцэл нь **Бодит хэлцлийн** зарчмаар явагддаг.


Үнэт цаасжуулалт-ИЗББ

“МИК ОССК” ХХК нь *Монголбанкны Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам, Орон сууц санхүүжилтийн журам* болон Засгийн газрын *Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам*д заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан зээлийн хөрөнгийг багцлан худалдан авдаг.

2020 онд 4 удаагийн хэлцлээр нийт 363.0 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгийн багц худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд үүний хүрээнд зээлийн хөрөнгийн багц бүрдүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж тус оны эхний хагас жилийн байдлаар 22, 23 дугаар ээлжийн хэлцлийн хүрээнд нийт 182.9 тэрбум төгрөгийн ИЗББ-ыг арилжаалаад байна. Түүнчлэн 24 дүгээр ээлжийн хэлцлээр нийт 112.4 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгийн багцыг бүрдүүлж, арилжааг 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдөр хийхээр төлөвлөн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудын олгосон 4,796 зээлийн хувийн хэрэгт хоёрдогч шинжилгээ хийсэн бөгөөд тэдгээр зээлүүдийн 76.39 хувь нь Зээлийн эрсдэлийн хорооны хурлын шийдвэрээр худалдан авах жагсаалтад бүртгэгдсэн байна.

Нийт ИЗББ-ын мэдээлэл




Эх сурвалж: "МИК ОССК" ХХК

2020 оны эхний хагас жилд худалдан авах жагсаалтад бүртгэгдсэн зээлүүдийн ангилал /сая ₮/

		Нийтийн зориулалттай орон сууц (8%)	Малчны зээл (8%)	Амины орон сууц (8%)	Нийтийн зориулалттай орон сууц (5%)	Амины орон сууц (5%)
ИЗББ 22	Зээлийн тоо	1,341	2	21	191	4
	Зээлийн дүн	86,723.9	82.5	953.3	7,429.6	174.6
ИЗББ 23	Зээлийн тоо	1,229	1	7	171	8
	Зээлийн дүн	80,209.9	38.2	578.5	6,489.9	265.2
Багцад эзлэх хувь		92.15%			7.85%	

Эх сурвалж: "МИК ОССК" ХХК

Багц бүрдүүлэлтийн 2020 оны эхний хагас жилийн төлөвлөгөө ба гүйцэтгэл




*Худалдан авалтын гүйлгээ хийх явцад тус дүнгүүд өөрчлөгдөх магадлалтай болно.

Эх сурвалж: "МИК ОССК" ХХК

Худалдан авсан зээлийн хөрөнгийн жагсаалтад орсон нийт зээлийн хөрөнгийн багцад 2,975 зээлийн данс багтанаас 2,003 зээл нь Улаанбаатар хотод олгогдсон бол 972 зээл нь орон нутагт олгогдсон зээлүүд байна.


22, 23 дугаар ээлжийн ИЗББ-ын багцын зээлд хамрагдалтын тархалт



Эх сурвалж: "МИК ОССК" ХХК

Тайлант хугацаанд худалдан авсан багц дахь зээлдэгчдийн өрхийн сарын дундаж орлого 2.7 сая төгрөг байгаа ба орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тал хувийг 2.0 сая төгрөгөөс ихгүй өрхийн орлого бүхий иргэд бүрдүүлсэн байна.

22, 23 дугаар ээлжийн ИЗББ-ын багцын зээлийн хөрөнгийн зээлдэгчдийн орлогын ангилал




Эх сурвалж: "МИК ОССК" ХХК

Ипотекийн зээлтэй иргэдийн орлогын хэмжээг харуулсан статистик үзүүлэлтүүд нь Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үйл ажиллагаанд дундаж болон дунджаас доогуур орлого бүхий иргэд хамрагдсан нь орон сууцны хэрэгцээ шаардлага өндөртэй өрхүүдэд илүү хүрснийг илэрхийлж байна.


22, 23 дугаар ээлжийн ИЗББ-ын багцын худалдан авалтад орсон орон сууцны зээлд хамрагдсан иргэдийн 46.9 хувь нь гэр хорооллоос амьдрах орчноо сайжруулан орон сууц худалдан авсан байна.

Тайлант хугацаанд 22, 23 дугаар ээлжийн ИЗББ-ын багцад худалдан авсан зээлийн барьцаа хөрөнгийн насжилтыг тодруулбал 2000 он болон түүнээс хойш ашиглалтад орсон барьцаа хөрөнгө бүхий зээл нийт багцын 91.7 хувийг эзэлж байна.

Барьцаа хөрөнгийн ашиглалтад орсон оны мэдээлэл



Ипотекийн зээлээр орон сууц худалдан авсан иргэдийн сууцны бүтэц /2020.6.30-ны өдрийн байдлаар/



Буцаах нөхцөлтэй хэлцэл

"МИК ОССК" ХХК нь өөрийн хөрөнгө, Германы сэргээн босголт хөгжлийн банкнаас авсан урт хугацаатай зээл болон "Өэлүн" бондын эх үүсвэрээр банкуудаас буцаах нөхцөлтэй ипотекийн зээлийн багц худалдан авах үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Уг хэлцэл нь "МИК ОССК" ХХК-ийн худалдан авсан зээлийн хөрөнгөд эрсдэл учирсан тохиолдолд тухайн зээлийн хөрөнгийг зээл олгосон банкинд буцаан худалдах, эсвэл өөр зээлийн хөрөнгөөр солих нөхцөлтэй хэлцэл юм.

Банкуудаас буцаах нөхцөлтэй багц худалдан авснаар банкинд эх үүсвэр шинээр бий болгож, хөрвөх чадварыг сайжруулахын зэрэгцээ дахин зээл олгох боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн банкны зээл олгох эх үүсвэрийн зардлыг бууруулж, хугацааг уртасгаснаар зээлдэгчийн орон сууцны зээлийн нөхцөлийг сайжруулдаг.

Тайлант хугацаанд 28.44 тэрбум төгрөгийн нийт 8 удаагийн буцаах нөхцөлтэй хэлцэл хийсэн ба үүнээс олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн "Өэлүн" бондын эх үүсвэрээр 1004 зээлдэгчийн 28.23 тэрбум төгрөгийн буцаах нөхцөлтэй 7 хэлцлийг гүйцэтгэлээ.

ГСБХБ-ны урт хугацаат зээлийн эх үүсвэрээр худалдаж авсан багцын эргэн төлөлтөөр 215.54 сая төгрөгийн зээлийг буцаах нөхцөлтэй хэлцлээр худалдан авсан бөгөөд тус эх үүсвэрээр худалдан авсан зээлийн багцын үлдэгдэл 4.96 тэрбум, Компанийн дотоодын эх үүсвэрээс худалдан авсан багцын үлдэгдэл 5.51 тэрбум төгрөгт тус тус хүрээд байна.

"Өэлүн" бондын эх үүсвэрээр худалдан авсан буцаах нөхцөлтэй багцын шинж чанар

Даатгалын төрөл	Нийт	
	Зээлийн тоо 1004	Дүн /тэрбум ₮/ 28.23
Багц дахь зээлүүдийн жигнэсэн дундаж хүү		19.26%
Багцын жигнэсэн дундаж зээл үнэлгээний харьцаа		29.54%
Багцын жигнэсэн дундаж зээлийн насжилт /сар/		24.24
Багцын жигнэсэн дундаж үлдэгдэл хугацаа /сар/		72.51
Барьцаа хөрөнгө байршил - Улаанбаатар хот		929
Барьцаа хөрөнгө байршил - Орон нутаг		75
Багцын зээлийн төлөгдөж дуусах сүүлийн огноо		2039.06.26

Эх сурвалж: "МИК ОССК" ХХК



“МИК Холдинг” ХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол,
14210 Энхтайваны өргөн чөлөө 19, Худалдаа Хөгжлийн Банкны байр, 13-р давхар

Утас: +976 11 328267

И-мэйл: info@mik.mn

www.mik.mn